



ЭРЧИМ МЭДЭЭ

Эх орны хөгжлийн баталгаа
Эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

№07 (135)

2022 оны 07-р сар

ЭНЭ ДУГААРТ:

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН" ЦОЛ ТЭМДГЭЭР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД

2-р нүүрт

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ЖУУХ БИЧИГ"-ЭЭР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД

3-р нүүрт

2022 ОНЫ 06-Р САРЫН ТЭЗҮ

4-р нүүрт

2022 ОНЫ 6-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

5-р нүүрт

КОД БИЧИЖ СУРАХЫН АЧ ХОЛБОГДОЛ + ҮҮНД ТУСЛАХ 5 АПП

6-р нүүрт

СПОРТЫН МЭДЭЭ

7-р нүүрт



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, сха@tpp4.mn

эсвэл Судалгаа Хөгжлийн Албанд файлаар болон бичгээр өгч болно.

www.tpp4.mn

"ДЦС-4" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ "ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-4" ТӨХК-ийн нийт ажилтнууд та бүхэндээ Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816, Үндэсний эрх чөлөө, Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100,101 жилийн ойн баярын мэндчилгээ дэвшүүлье!

Ү. Төмөрхуяг
Гүйцэтгэх захирал



Энэ их ойн баяр наадмаар Үндэсний шагайн харваан тэмцээнд, ЗЦ-ийн сэргээн засварлах, тосолгоо үйлчилгээний бригадад ажиллаж байсан Т.Баярбат уугуул нутаг Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сум, "Шонхор" багаас оролцон нийт 98 багаас 3 дугаар байр эзэлж, хүрэл медаль хүртлээ. Ийнхүү 2015 онд Улсын Аварга Шалгаруулах Тэмцээнээс багаараа мөнгөн медаль хүртэж Монгол Улсын мэргэн цол авч байсан бол энэ удаад цолоо ахиулан Монгол Улсын

хошой мэргэн цол хүртлээ. Тэрээр 2000 оноос Монгол өв уламжлалаа сэргээн хөгжүүлэхээр тууштай хүчин зүтгэж үндэсний шагайн спортын төрлөөр Улс, аймгийн алдар цолтон 40 гаруйг төрүүлж, багш шавь нар энэ жилийн наадмаар хавтай сайхан наадлаа. МУ-ын хошой мэргэн Баярбат танд "Даяар дуурсах дархан мэргэн" цолтон болохыг нийт компанийнхаа хамт олны нэрийн өмнөөс хүсэн ерөөе!


**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”
ЦОЛ, ТЭМДЭГЭЭР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД**

№	Овог нэр	Албан тушаал
1	Нансалмаа Сэлэнгэ	Түлш дамжуулах цехийн цахилгаан гагнуурчин
2	Мөнхдорж Бямбасүрэн	Түлш дамжуулах цехийн вагон хөмрөгчийн машинч
3	Шонтгор Батсүх	Түлш дамжуулах цехийн ээлжийн цахилгааны монтёр
4	Энхээ Наранчимэг	Түлш дамжуулах цехийн бутлах төхөөрөмжийн машинч
5	Отгонбат Ганпүрэв	Түлш дамжуулах цехийн тоноглолын засварчин
6	Самбуу Азжаргал	Зуухан цехийн ээлжийн дарга
7	Шархүү Баярсайхан	Зуухан цехийн зуух болон тоос бэлтгэх тоноглолын засварчин
8	Мэндээ Ариунбат	Зуухан цехийн зуух болон тоос бэлтгэх тоноглолын засварчин
9	Рагчаа Лхагвасүрэн	Зуухан цехийн зуухны машинч
10	Лхагвасүрэн Батсүх	Турбин цехийн тохируулга тосолгооны системийн засварчин
11	Мишиг Батхуяг	Турбин цехийн туслах тоноглолын щитний машинч
12	Зинамядар Лхагва-Эрдэнэ	Турбин цехийн ус хангамжийн ээлжийн монтёр
13	Балжинням Мэндсайхан	Турбин цехийн арматур шугам хоолойн засварчин
14	Лхагва Гантөгс	Цахилгаан цехийн цахилгаан тоноглолын засварын инженер
15	Гачинлам Сугар	Цахилгаан цехийн тоосон системийн реле хамгаалалт автоматикийн монтёр
16	Дагвадорж Лхагвасүрэн	Цахилгаан цехийн ороомог хөндийрүүлгийн засварын монтёр
17	Болдбаатар Ууганболд	ДХХА цехийн ашиглалтын инженер
18	Цэдэндорж Ганболд	ДХХА цехийн даралт, түвшин, зарцуулалтын хэмжүүрийн инженер
19	Лхагвасүрэн Батмөнх	ДХХА цехийн ээлжийн засварчин
20	Эрдэнэбат Намжин	Хими цехийн засварын мастер
21	Төмөрбаатар Наранцэцэг	Хими цехийн щитний машинист
22	Содном Энхбат	Механик цехийн токарьчин
23	Санжмятав Батжаргал	Механик цехийн арматурын засварчин
24	Галсанням Батжаргал	Механик цехийн шат бэхэлгээний мастер
25	Батсэрээнэн Бямба-Эрдэнэ	Механик цехийн цахилгаан хийн гагнуурчин
26	Дулам Мөнхбат	Авто аж ахуйн хогны машины жолооч
27	Таванжин Баатархүү	Авто аж ахуйн ачааны машины жолооч
28	Цэндаюуш Эрдэнэсайхан	Эрчим зоог цайны газрын хоол үйлдвэрлэлийн ахлах тогооч
29	Ваанчиг Энхсайхан	Эрчим зоог цайны газрын заал зохион байгуулагч
30	Бямбаа Оюун-Эрдэнэ	Эрчим зоог цайны газрын аяга таваг угаагч
31	Цэнгэл Болормаа	Эрчим зоог цайны газрын ээлжийн кассчин
32	Сэсээр Цэрэннадмид	Эрчим зоог цайны газрын ээлжийн ахлах тогооч
33	Лувсантарав Энхсайхан	Эрчим зоог цайны газрын оператор-кассчин
34	Түмэнбаяр Оргил-Эрдэнэ	Захиргаа хүний нөөцийн албаны сургалтын менежер
35	Доохүү Одноо	ТЭЗХ-ийн засгийн хэлтсийн тоноглолын төсөв хариуцсан мэргэжилтэн
36	Буянцог Баясгалан	Судалгаа хөгжлийн албаны архивын мэргэжилтэн
37	Чадраабал Балжинням	Нийгэм ахуйн хэлтсийн жижүүр цаг бүртгэгч
38	Нацагдорж Оюунчимэг	Нийгэм ахуйн хэлтсийн угаагч үйлчлэгч

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ “ЖУУХ БИЧИГ”-ЭЭР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД

№	Овог нэр	Албан тушаал
1	Очирхүү Чинбат	Түлш дамжуулах цехийн туузан тэжээгчийн машинч
2	Сэнгээ Батсайхан	Түлш дамжуулах цехийн хөдөлгүүр, өргөх зөөх механизмын монтёр
3	Гантөмөр Саруул-эрдэнэ	Түлш дамжуулах цехийн ахлах замчин
4	Гончигзэвгэ Энхбаяр	Түлш дамжуулах цехийн тоноглолын ээлжийн засварчин
5	Лхагвасүрэн Очирбат	Зуухан цехийн зуух болон тоос бэлтгэх тоноглолын засварчин
6	Хөххүү Жавхлан	Зуухан цехийн зуухны машинч
7	Жигжид Баярмагнай	Зуухан цехийн туслах тоноглолын машинч
8	Дорж Сайнтөр	Зуухан цехийн туслах тоноглолын машинч
9	Намжилмаа Ганцоож	Зуухан цехийн цахилгаан гагнуурчин
10	Борхүү Чинзориг	Турбин цехийн цахилгаан гагнуурчин
11	Баярсайхан Пүрэвжав	Турбин цехийн цахилгаан гагнуурчин
12	Дашзэвэг Цацралмаа	Турбин цехийн тэжээлийн усны төхөөрөмж, деаэраторын машинч
13	Цэдэнбал Энхмэнд	Турбин цехийн турбины машинч
14	Мижддорж Одгэрэл	Турбин цехийн турбины машинч
15	Санжмятав Гантулга	Цахилгаан цехийн ээлжийн ахлах монтёр
16	Өлзийбат Мөнхмагнай	Цахилгаан цехийн цахилгаан машины засварын цахилгааны слесарь
17	Ганбат Халиунаа	Цахилгаан цехийн удирдах щитний цахилгааны монтёр
18	Эрдэнэбат Элбэгсайхан	ДХХА цехийн гүйцэтгэх механизмын засварчин
19	Ганбаатар Янжиндулам	ДХХА цехийн хэмжүүрийн засварчин
20	Лхаасүрэн Номин	Хими цехийн ээлжийн лаборант
21	Элбэгзаяа Мөнхзаяа	Механик цехийн цахилгаан хийн гагнуурчин
22	Содном Цасанчихэр	Механик цехийн арматурын засварчин
23	Барсүрэн Батбаяр	Механик цехийн сэргээн засварлахын мастер
24	Мөнхөө Сарантунгалаг	Үйлдвэрлэлийн албаны цахилгаан техникийн тооцооны техникч
25	Цэрэндорж Мөнхзаяа	Санхүү бүртгэлийн хэлтсийн материалын нягтлан бодогч
26	Батчулуун Булгаа	Санхүү бүртгэлийн хэлтсийн материал сэлбэг хариуцсан нярав
27	Ганболд Өлзий-дэлгэр	Санхүү бүртгэлийн хэлтсийн материал сэлбэг хариуцсан нярав
28	Отгонбаатар Хосбаяр	Хяналтын албаны нүүрсний сорьц авагч, бэлтгэгч

That Might Motivate You №5



2022 ОНЫ 06-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавраас 5825.964 мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, 2417.569 мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг 3.4 сая.кВтц-аар давуулан биелүүлсэн. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал 410 МВт, дээд ачаалал 501 МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	286.5	289.9	3.4	101.2%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	159.3	159.3	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - **101.2%**, ДЭХ - **100,0%** биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил	
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	удаа	мян.кВтц
66	5825.964	24	1601.651	4	2417.569	501	410	3408.395	152.0	2927.216

Тайлант сард 5 зуух, 5 турбины горимоор 10 хоног, 5 зуух, 4 турбины горимоор 20 хоног ажиллах төлөвлөгөөтэй боловч хэрэглээний өсөлттэй холбоотой 5 зуух, 5 турбинтэй тасралтгүй ажиллаж УСТ-д тусгагдсан ЦЭХ-г 17,8 мян.кВтц-аар давуулан биелүүлсэн. ЦЭХ-ний боловсруулалт өнгөрсөн онтой харьцуулахад 5,7 сая.кВтц-аар буурсан бөгөөд шөнийн бага ачаалалд /0-8 цагт/ 9,7% буурч, өдрийн ачаалалд /8-16 цагт/ 61,9%, оройн оргил ачаалалд 47,7% нэмэгдсэн.

Манай компани зуухнуудын хамгийн бага ачааллыг 350т/ц-аас доош бууруулахгүй ажиллах бодлого барьж ажилласан бөгөөд хэрэглээний бууралт гарч, экспорт нэмэгдсэнтэй холбоотой “ДҮТХХК” -аас 152,0 мян.кВтц-н нэмэх зөрчил ноогдуулсан байна.

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд **420,898** мян.кВтц буюу **38577,468** мян.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, **155,235** мян.кВтц буюу **5328,01** мян.төгрөгний ЦЭХ худалдан авч, авлага өглөгийн зөрүүгээр **33,2** сая.төгрөгний ашигтай ажиллалаа. Өссөн дүнгээр **142,8** сая.төгрөгний авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс **17,8** сая.кВтц-аар давуулан **106,5** %-н биелэлттэй, оны эхнээс **138,9** сая.кВтц-аар давж, **107,0** %-ийн биелэлттэй байна.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд 6 зуух, 6 турбин оролцсон. Сарын дунджаар **4,84** зуух, **4,96** турбинтэй ажиллаж зуух, турбин бэлтгэлгүй байлаа.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	135.0	136.299	+1.299	101.0%
Шивээ-Овоо	мян.тн	110.0	110.886	+0.886	100.0%
Бүгд	мян.тн	245.0	247.185	+2.185	100.9%

Мазутын зарцуулалт

Энэ сард **100** тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс **142** тн-г түлж, **42** тн мазутын хэтрэлт гарсан.

Тайлант хугацаанд **7** удаагийн хүйтэн галлагаа, **1** удаагийн халуун галлагаа хийсэн.

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - **0,08** гр/кВтц-аар, дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг - **1,033** кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс **188** тн жишмэл түлш буюу **402** тонн бодит түлш /илчлэг **3279** ккал/кг/ хэмнэсэн.

6-р сарын горим ажиллагаа анхны төлөвлөлтөөс ЦЭХ түгээлт **4.9** сая.кВтц-аар нэмэгдэж, ДЭХ түгээлт **2.4** мян.Гкал-аар буурсан.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ-аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг **0,28**%-иар буюу **920,013** мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Тайлант сард трансформаторын алдагдлыг төлөвлөлтөөс **0,23**% бууруулж ажилласан. Өссөн дүнгээр **0,14**% бууралттай байна.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	6-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/ тн.нүүрс	30.28	29.52
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/ тн.уур	5.07	4.94
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.тэж ус	8.90	8.67
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	1.46	1.42
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/ тн.сүлж.ус	0.53	0.52

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөсөн хэмжээнд барьж ажилласан. Осмосын халаагч уурын зарцуулалт **4099** тн байлаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт **9211** тонноор нэмэгдсэн. Оны эхнээс **15,3** мян.тонноор өссөн байна.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд - **50710м3**
- Зууханд - **1043 м³** уг өсгөн.
- БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - **16459 м³** байлаа.

2022 ОНЫ 06-Р САРЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2022 оны 6-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 11 бүртгэгдсэнээс зуух 8 удаа, турбин 3 удаа тус бүр зогссон.

Хүний буруутай үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2021 оны 6-р сар	2022 оны 6-р сар	2021 оны 6-р сар	2022 оны 6-р сар	2021 оны 6-р сар	2022 оны 6-р сар	2021 оны 6-р сар	2022 оны 6-р сар	2021 оны 6-р сар	2022 оны 6-р сар
1	Зуух	1	4	1	-	-	-	-	4	2	8
2	Турбин	1	-	1	1	-	-	1	2	3	3
	Дүн	2	4	2	1	-	-	1	6	5	11

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ТЦ-2 /3.157,147 мян₮/ бүгд-2 /3.157,147 мян₮/
- Мазут зарцуулалтын акт: ЗЦ-7 /179.698,375 мян₮/, ЦЦ-1 /10.539,632 мян₮/ бүгд-8 /190.238,007 мян₮/
- Тоноглолын аварийн зогсолтыг судалсан акт: ЦЦ-1 /шууд хохирол гараагүй/ бүгд-1
- Тоног төхөөрөмж сэлбэг материал ашиглалтаас хасах акт: ДХХАЦ-1 бүгд-1

Нийт 12 ширхэг /193.395,154 мян₮/ акт тогтоогдсон.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	27 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	20 удаа ажлын байранд хяналт хийсэн.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	К-6 –ийн тоосон ситемийн болон халах гадаргуугийн их засвар, Зуух №2 –ын тоосон системийн засвар, ДСП-5 –ын их засвар, яндангийн барилгын засварт хяналт тавьж байна. 7М-300 хаалтны засварын ажилд, К-2 –ын хүчлийн угаалтанд тус тус хяналт тавьсан.

2. Сургалт, зааварчилгаа

1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	275 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	19 иргэнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	29 ажилтнаас шалгалт авсан.

3. ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР


1	МХЕГ ХАБҮЛ –тай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	Хяналт тавьж ажиллаж байгаа.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Хими цехэд гарсан осолтой холбоотой 6–н сард ХЦ –д хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийв.

- УЗН, НОБГ –тай хамтарч гамшгийн үеийн онол, дадлага сургалт зохион байгуулсан.
- Осол мэдээллийн даалгавар 2022/02, Сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар №01/22 –ын гүйцэтгэл гаргаж холбогдох газарт хүргүүлсэн.
- Хими цехэд гарсан ослын дүн шилжилгээний хурлыг зохион байгуулсан.
- БМА –тай холбоотой нарядын зөрчлийг ИЛТГЭХ ХУУДАС –аар танилцуулсан.
- “Эрчим зоог” цайны газрын хоолны боловсруулалт, хүнсний материал хүлээн авах, зарцуулах, бүртгэх журамд саналаа өгсөн.
- Хор саармагжуулах бүтээгдэхүүний эзэлхүүн гэрээнд заасны дагуу хэмжээнд хүрээгүй талаар ЭЗЦГ, ХААХ –ийн холбогдох мэргэжилтнүүдтэй /5–р сарын 30–ны 5ш, 6–р сарын 2ш нийт 7–н ширхэг сүү/ хэмжилт хийхэд: дунджаар 225 мл буюу 25 мл –ээр ДУТУУ байсан нь тогтоогдсон. “Мон Сүү” ХХК –нд албан бичиг хүргүүлж зөрчлийг арилгуулсан.
- 2К-211, 212, 213 хаалтуудын засварын ажилд хяналт тавьж байна.
- Авто аж ахуйн жолооч Г.Т нь 6–р сарын 15–ны өдөр 15:30 минутын орчимд ажлаас гарч 5–н шарын СУТАЙН БУЯНТ худалдааны төв орохоор явж байх үедээ авто замын осолд орсон /Мотоциклээр замын хөдөлгөөнд оролцож байсан/.

- Сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар №02/22–г гаргаж нэгжүүдэд түгээсэн.
- Өндрийн бүс шалгах стенд шинээр хийлгэж 40–н ажилтанд сургалт явуулсан.
- 7–н цехийн ХАБ –ын хуралд оролцож, ИТА нартай уулзалт зохион байгуулсан.
- ХАБ–ын угтах үдэх самбар байршуулсан.
- 2022 оны 6 дугаар сарын 23–ны өдрийн 09 цаг 30 минутын үед “МЭЗ” ХХК –ийн ажилтан Ц.А /дагалдан/ зуух №2 –ын тоосон системийн дунд засварын ажилд 560 –ын диаметртай, 1500 мм –ийн урттай нерж хоолойг m11–2А –ийн тавцан дээр цахилгаан талиар гаргаж дэгээг мултлах үйлдэл хийж байхдаа нерж хоолойн дээд ирмэг болон цахилгаан тальны дэгээний хооронд баруун гарын тавдугаар хурууны нэгдүгээр үе нь хавчуулагдаж, өндөгний арьс зүсэгдсэн. АЮУЛТАЙ ТОХИОЛДОЛ гарсантай холбоотой “МЭЗ” ХХК –нд АЛБАН ШААРДЛАГА бичсэн. Сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар №03/22 –г гаргаж нэгжүүд, гадны гүйцэтгэгч компаниудад түгээсэн.
- Нийлүүлэгдсэн үхрийн мах шаардлага хангаагүй тул буцааж, шинэ мах хүлээж авсан.
- ХАБ –ын III шатны үзлэгийг зохион байгуулсан.

КОД БИЧИЖ СУРАХЫН АЧ ХОЛБОГДОЛ + ҮҮНД ТУСЛАХ 5 АПП

КОД БИЧИЖ СУРАХЫН АЧ ХОЛБОГДОЛ



Технологийн мэдлэгээ нэмэгдүүлэх

Бид эргэн тойрон дахь бүхий л зүйлс маань ямар нэг хэмжээнд технологийг өөртөө шингээж, ашиглаж байгаа үед амьдарч байгаа билээ. Магадгүй хэдхэн жилийн дараа гэхэд технологи ашигладаггүй компани олдохоо байна биз. Ийм үед код бичиж сурах нь ямар ч газар таны үнэ цэнийг нэмж чадах юм. Та өөрийг тань хүрээлж буй технологиудыг гүнзгий ойлгож мөн тэдгээрийг өөрт тохируулан өөрчилж хэрэглэх чадвартай болно. Жишээ нь: Та компьютерынхаа үйл ажиллагааны статистикийг хянах, эсвэл имэйл, мессежнүүдийг хүлээн авах тохиргоондоо өөрчлөлт оруулж, ажлаа хөнгөлж болох юм.

Логик, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүл


"Энэ улсын бүх хүн код бичиж сурах хэрэгтэй. Учир нь энэ чамд яаж бодохыг зааж өгнө." гэж Стив Жобс хэлсэн байдаг аж. Программист хүмүүст ямар нэг асуудал тулгарахад тэд юу юугүй код бичээд эхэлнэ гэж байдаггүй. Асуудлыг тэгж шийдэх нь боломжгүй. Харин түүнийг жижиг хэсгүүдэд хуваан түүн дээрээ ажилладаг. Код бичдэг хүмүүст энэ арга барил аль хэдийн дадал болсон байх нь элбэг бөгөөд аажмаар аливаа асуудлыг шийдвэрлэхдээ цэгцтэй хандаж, логиктой сэтгэж эхэлдэг. Улмаар асуудлаа сайтар ойлгосноор илүү бүтээлч шийдлийг олоход тусалдаг байна.

Өөрийн вебсайтыг хөгжүүлэх

Wordpress эсвэл Weebly зэрэг талбаруудыг ашиглан өөрт хэрэгтэй вэбсайтаа бүтээх боломжтой ч, код бичиж сурснаар та олон төрлийн хэлийг ашиглан бусдаас ялгарах сайтыг бүтээж чадна. Жишээ нь: Компанийн вэбсайтаа бусдаас хамаарахгүйгээр, хямд өртгөөр, өөрийн төсөөллөөр бүтээх боломжийг кодын мэдлэг өгдөг. Түүнээс гадна вэбсайт хөгжүүлэх чадвартай болно гэдэг бол ажлын талбарт ч өрсөлдөх чадвараа үлэмж нэмэгдүүлнэ гэсэн үг. Харин дараа нь ямар зорилготой байгаагаас хамаараад ямар программын хэл судлах вэ гэдгээ шийднэ:


- HTML болон CSS – Вэбсайтын гаднах төрх, текст, товчлуур, тэдний хэмжээ ба өнгийг тохируулахад;
- Python болон Ruby – Вэбсайтын back-end code буюу үйл ажиллагааны ард байдаг код буюу логикийг бичихэд;
- Java – Андроид үйлдлийн системд зориулсан аппликейшн хөгжүүлэхэд (Javascript – вэбсайтыг хэрэглэгчтэй илүү ойртуулах буюу илүү interactive болгоход);
- Objective-C / Swift – iOS аппликейшн хөгжүүлэхэд;
- C++ – Компьютерын үйл ажиллагаанд хэрэгтэй программ, тоглоом болон аппликейшн хөгжүүлэхэд тус тус ашиглагддаг.

1. SOLOLEARN



SoloLearn нь дан ганц апп биш бөгөөд аппуудын цуглуулга гэж хэлж болно. Та ямар хэл сурахыг хүсч байгаагаас шалтгаалан аппаа татаж авах хэрэгтэй юм. Жишээ нь, вебсайт хийхийг хүсч байвал HTML эсвэл CSS, харин апп бичиж сурахыг хүсч байвал Java-г татаж авах нь тохиромжтой. Эдгээр программын хэлүүдийг дотроо үндсэн ойлголт, бүтэц гэх мэтээр жижиг хичээлүүдэд хуваасан байх ба хичээл бүр нь тесттэй тул сурсан эсэхээ хялбар шалгаад явах нь ээ. Түүнчлэн эдгээр оноогоор дэлхий даяар энэ аппыг ашигладаг хүмүүсийг жагсаасан байх бөгөөд сурах үйл явцыг улам л өрсөлдөөнтэй, хөгжөөнтэй болгоно. Хамгийн гоё нь ийм их зүйлсийг өөртөө багтаасан энэхүү аппууд бүгд үнэгүй аж.


2. EDX



Онлайнаар сурахыг зорьж буй хүн бүр edX-г андахгүй биз ээ. Тэдний хичээлүүд дунд код бичиж сурахыг эрмэлзэж буй хүмүүст зориулсан анхан шатны ба гүнзгий түвшний хичээлүүд

олон буй. Бүхий л хичээлүүд нь гаднын нэртэй сургуулиуд, байгууллагуудтай хамтарсан байдаг тул чанартай хичээлийг үнэгүй үзээд явах маш гоё боломж юм. Түүнчлэн тодорхой хэмжээний мөнгө төлөөд мэргэжлийн сертификат хүртэл авах боломжтой. Яг одооноос авхуулаад үзэх боломжтой хичээлүүдээс дурьдвал, MIT-аас гаргаж буй Python хэлний хичээл, HKUST-ээс гаргаж буй Java хэлний анхан шатны хичээлүүд байна. Эдгээрээс гадна программын хэлний маш олон хичээл байгаа тул өөрт тохирсныг сайтар хайгаад үзэх нь зүйтэй.


3. UDACITY



Энэ апп-ийн хамгийн том давуу тал бол Google зэрэг томоохон компаниудтай хамтран өөрсдийн хичээлүүдийг бэлддэг. Зарим хичээлүүд нь үнэгүй ч үнэхээр Udacity-г тултал нь ашиглая гэвэл

мөнгө төлөх шаардлагатай. Үнэтэй хичээлүүд нь мэргэжлийн хүмүүсээс тусламж авах, хичээл хамт үзэж буй хүмүүстэй харилцаж хоорондоо хэлэлцэх гэх мэт боломжийг олгодог. Гэхдээ Udacity-н хичээлээс та сертификаттай төгсөхийг хүсч байвал сарын 200\$ төлөх баямархурдаар яаж үзэхээсээ шалтгаалан хэдэн сарын төлбөр төлөх нь тодорхой болох юм. Үнэтэй сонсогдож байж магадгүй ч курсээ дуусгасны дараа мэргэжлийн зэрэгтэй дүйцэхүйц сертификаттай болохоос гадна AT&T хэмээх газруудад боломжит ажлын байрыг санал болгодог байна.

СПОРТЫН МЭДЭЭ



“ЭРЧИМ” КЛУБ ҮНДЭСНИЙ ДЭЭД ЛИГТ 13 ДАХЬ УДААГАА АВАРГАЛЛАА

Монголын хөлбөмбөгийн хамгийн нэр хүндтэй тэмцээн болох “Моби үндэсний дээд лиг”-ийн тэмцээн улирлын турш гайхалтай өрсөлдөөнтэй үргэлжилж, “Хаан Хүнс Эрчим” 13 дахь аваргын цомоо өргөлөө.

1996 оноос эхлэлтэй үндэсний дээд лигийн түүхэнд “Эрчим” клуб 23 удаа оролцож, 1996, 1998, 2000, 2002, 2007, 2008, 2012, 2013, 2015–2018 онуудад 12 алт, 1997, 1999, 2009, 2014, 2019 онуудад 5 мөнгө, 2003 онд 1 хүрэл медаль хүртэж байсан ч сүүлийн 2 улирлын туршид аваргын байраа алдан 4. 5–р байрыг эзэлж байлаа.

Энэ удаад түүхэн дээд амжилтаа бататган, эрхэм хүндтэй цолыг багтаа эргүүлэн авчрахад үлэмж нөлөө үзүүлсэн ТДЦ-ийн

дамжлагын машинч, хаалгач Б.Ариунболд, ЗЦ-ийн хамгаалагч Г.Билгүүн, Япон улсын тамирчин довтлогч Мишима Юүта нар байрлал тус бүрдээ “Лигийн шилдэг тоглогч”-оор тодорч хөгжөөн дэмжигчдийнхээ баяр дээр баяр нэмсэн юм.

MOBI PREMIER LEAGUE

MOBI PREMIER LEAGUE CHAMPIONS

ХААН ХҮНС ЭРЧИМ

MOBI PREMIER LEAGUE

3.000.000T ШИЛДЭГ ХАМГААЛАГЧ

Г.БИЛГҮҮН

ШИЛДЭГ ХАМГААЛАГЧ

MOBI PREMIER LEAGUE

3.000.000T ШИЛДЭГ ДОВТЛОГЧ

МИШИМА ЮУТА

ШИЛДЭГ ДОВТЛОГЧ

MOBI PREMIER LEAGUE

3.000.000T ШИЛДЭГ ХААЛГАГЧ

Б.АРИУНБОЛД

ШИЛДЭГ ХААЛГАГЧ



С, Д АМИНДЭМ



С аминдэм нь усанд уусдаг аминдэм бөгөөд хүний биед чухал хэрэгцээтэй аминдэмүүдийн нэг юм. Усанд уусдаг учраас хүний биед хуримтлагдаггүй.

С аминдэмийн ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

- БИЕЭЭС ХОРЫГ ЗАЙЛУУЛНА
- Биед орсон зарим хортой бодисыг саармагжуулж, хоруу чанартай нэгдэл үүсэлтийг саатуулна. Иймээс химийн үйлдвэр, хортой нөхцөлд ажиллагсадын хоолны с аминдэмийн агууламжийг нэмэгдүүлэх шаардлагатай байдаг.

ДАРХЛАА

- Дархлааны элемент болох цусны цагаан эсийн найрлаганд С аминдэм өндөр агууламжтай байдаг.
- Цусны цагаан эс дархлааны хариу урвалд идэвхжин бэлтгэгдэх үед гадны биеийг устгахдаа өөрийн дархлааны эсийг устгах үзэгдэл гардаг. С аминдэмийн өндөр агууламж нь дээрх “өөрийгөө устгах” ажиллагааг бууруулна.

ТӨМРИЙН ШИМЭГДЭЛТ

- Төмөр нь хүний бие организмд хүчилтөрөгч зөөвөрлөх, цусны бүтцэд чухал үүрэгтэй.
- С аминдэм нь ходоод гэдэсний замд төмрийн шимэгдэлт шингээлтийг нэмэгдүүлдэг.

Хэрэглээ: Насанд хүрсэн

- Эрэгтэйд 90 мг/өдөр
- Эмэгтэйд 75 мг/өдөр

Шээсээр С аминдэм хамгийн бага ялгарах үед цусны цагаан эсд хамгийн их агуулагдах хэмжээнд ойролцоогоор тулгуурлан зөвлөмж хэмжээг боловсруулсан.

Дараах тохиолдлуудад зөвлөмж хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай

- Тамхи татах (бие махбодид исэлдэлтийг нэмэгдүүлдэг)
- Түлэгдэлт ба эд нөхөх мэс заслын дараа (коллаген их хэмжээгээр нөхөн төлжих шаардлагатай болдог)

С АМИН ДЭМИЙН ЭХ СУРВАЛЖ

- Жимс, киви, ялангуяа цитрусийн төрлийн жимс.
- Хүнсний ногоо, төмс, ногоон чинжүү, цэцэгт байцаа, бөөрөнхий байцаа

- Нохойн хошуу болон исгэлэн сүүн бүтээгдэхүүн, айраг

ДУТЛЫН ҮЕД ГАРАХ ӨӨРЧЛӨЛТ

- Ядрах, дархлаа муудаж, халдварт өвчинд өртөмтгий болно.



→ Нүдний хараа муудна. Буйл хавдаж цус шүүрнэ.



→ Арьс хуурайшиж, үс өнгөө алдаж, хуруу хумс хөхөрч толбо үүснэ.

Д аминдэм



- Д аминдэм нь биед эрдэсийн тэнцвэрийг хадгалахад зайлшгүй шаардлагатай тосонд уусдаг нэгдлийн бүлэгт өгөгдсөн ерөнхий нэр юм.

- Д аминдэмийн химийн бүтцийг 1930-аад онд тодорхойлсон. Үндсэн хэлбэрүүд нь Д2 (ургамал, дрожжи, мөөг), Д3 (холекальциферол: амьтны гаралтай)

Д аминдэмийн ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

- Булчингийн үйл ажиллагаа, мэдрэл, цусны бүлэгнэлт, ясны эдийн хэвийн бүтэц болон эрдэсжилт зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Д амин дэм нь ердийн кальци, фосфорын цусан дахь концентрацийг хянахад чухал үүрэгтэй.
- Мөн эсийн тархалт, дархлааны хариу урвал, инсулины шүүрлийг хянахад чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг.

Аминдэм Д дутагдал :

- ХҮҮХДЭД: Хүүхэд цухалдуу, хөлрөмтгий, ерөнхийдөө сулбагар, шүдний хөгжил оройтох, амьсгалын замын өвчинд өртөмтгий.
- НАСАНД ХҮРСЭН ХҮНД: Насанд хүрэгчид ядрах, булчин, аарцаг, доод мөч янгинаж өвдөх, доголох, яс сийрэгжих, шүд үйрэх г.м

Аминдэм Д-ийн хоруу чанар буюу илүүдэл

- Уг аминдэм хүний биед өндөр тунгаар (25–50мкг) орсон тохиолдолд кальцийн шимэгдэлт хэтэрч, бөөр, зүрх зэрэг дотор эрхтэн, судсанд ихээр хуримтлагддаг. Ядрах, тамиргүйдэх. хоолонд дургүй болох, дотор муухайрах, гүйлгэх, бөөлжис цутгах, толгой өвдөх, ухаан самуурах, шээс задгайрах зэрэг нь хоруу чанарын илрэл болно.
- Бага насны хүүхдэд оюуны хөгжил саатах нүүр царайны хэлбэр нь өөрчлөгдөх, өсөлт удаашрах зэрэг сөрөг нөлөөтэй.

Хоолоор орсон аминдэмийн 70–90% нь шимэгддэг тул хүнсний нэмэлт хэрэглэхээс илүүтэйгээр С аминдэмээр баялаг хүнсний ногоо, жимс жимсгэнэ түлхүү хэрэглэхийг зөвлөж байна.

ЭЗЦГ Хоол зүйч Г.Пунсалмаа